



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2025 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 269

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг
шинэчлэн тогтоож, балансаас балансад
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сонгинохайрхан дүүргийн Прокурорын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, хуримтлагдсан элэгдлээрээ өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжтой 12,580,000.00 (арван хоёр сая таван зуун наян мянга) төгрөгийн балансын үнэ, элэгдэл бүхий автомашины ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 12,000,000.00 (арван хоёр сая) төгрөгөөр шинэчлэн тогтоож, хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Улсын ерөнхий прокурорын орлогч прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Сонгинохайрхан дүүргийн Прокурорын газрын Ерөнхий прокурор Д.Отгонбаяр, “Чингис хаан үндэсний баялгийн сан” ХХК-ны гүйцэтгэх захирлын үүргийг үүрэг гүйцэтгэгч Б.Тэмүүлэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.3. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

133001327
12-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн
..... дугаар тогтоолын хавсралт

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ПРОКУРОРЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
"ЧИНГИС ХААН ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САН" ХХК-Д АШИГЛАХ ХУГАЦАА, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООЖ,
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Автомашинны нэр, төрөл	Үйлдвэрлэгдсэн, ашиглалтад орсон огноо	Арлын дугаар	Улсын дугаар	Балансын үнэ, Хуриимтлагдсан элэгдэл (төгрөг)	Цаашид ашиглах хугацаа (жил)	Шинэчлэн тогтоосон үнэ (төгрөг)
1	Nissan Teana маркийн суудлын автомашин	10/11/2011	JN1BAUJ32Z0000625	2146УКМ	12,580,000.00	3	12,000,000.00
НИЙТ ДҮН					12,580,000.00		12,000,000.00
					(арван хоёр сая таван зуун наян мянга)		(арван хоёр сая)